



2023 он 02 сар 17 өдөр

Дугаар 23101

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

"Ногдол ашиг хуваарилах тухай"

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, "Үндэсний Хувьчлалын Сан" хамтын хөрөнгө оруулалтын сан ("ХОС" гэх)-ийн дүрмийн 12 дугаар зүйл, 16 дугаар зүйлийн 16.3 дах хэсэг, ХОС-ийн ногдол ашгийн бодлогыг тус тус удирдлага болгон ХОС-ийн төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны ашгаас нийт нэгж эрх эзэмшигчдийн нэг нэгж эрхэд 2.3 (хоёр төгрөг гурван мөнгө) төгрөг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй нэгж эрх эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 сарын 14-ний өдрөөр тогтоож, ногдол ашгийг 2023 оны 7 сарын 10-ны өдрийн дотор төлөхөөр шийдвэрлэсүгэй.
3. Нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулахыг сангийн менежер /Ч.Даваасамбуу/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Г.ЦОГБАДРАХ

